



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 4/809

Эрдэнэт

Туршлага судлах арга хэмжээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 /а/, 29.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 6/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Эмч” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Тайландын вант улсын эрүүл мэндийн байгууллагын удирдлага зохион байгуулалт, эмчилгээний чанар, аюулгүй байдал, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажлын туршлага солилцох арга хэмжээнд аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнхцэцэг нь 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс оролцох тул санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 2500000 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийн 1600000 /Нэг сая зургаан зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2018 оны “Эмч” хөтөлбөрийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/194 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд болон 3 дахь шатлалын эмнэлэгт эмч, эмнэлгийн ажиллагсадын ажил мэргэжлийн туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх” зардлаас, 900000 /Есөн зуун мянган/ төгрөгийг “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аяныг зохион байгуулах, үйл ажиллагааг дэмжих” зардлаас тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

0201804190